

**АНУ-ын Тусгаар тогтнолын өдөрт зориулсан хүлээн
авалт дээр 1997 оны долдугаар сарын 4-ны орой
АНУ-ын хэргийг түр хамаарагч Ллиуллин Хэжбэтийн
хэлсэн үг**

Улсын Их Хурлын ноён Орлогч дарга, Гадаад Харилцааны ноён сайд, эрхэмсэг сайдууд, хүндэт зочид- анд нараа!

Та бүхэнд оройн мэнд дэвшүүлж, баяр хүргэе!
Түүнчлэн Монголд анх удаа айлчилж байгаа Азийн Фондын ивээн тэтгэгч ноён Паул Слаусон, Олон Улсын сэтгүүлч Том Брокау нарт баяр хүргэе!

Америкийн нэгдсэн улсын тусгаар тогтнолын өдрийг та бүхэн бидэнтэй хамт тэмдэглэж байгаал би баяртай байна.

Энэ бол Америкийн Нэгдсэн Улсын үндэсний баярын өдрийг бидэнд Улаанбаатарт аравдахь удаа тэмдэглэж байгаа явдал юм.

Бусад үе шатны нэгэн адил АНУ, Монголын хооронд албан ёсны харилцаа тогтоосноос хойш өнгөрсөн арван жилд та бид хамтдаа ихээхэн ахиц ололтод хүрч, манай хоёр орны улс төр, эдийн засаг, боловсрол, соёлын хэлхээ холбоог өргөжүүлэн хөгжүүлэв. Түүнчлэн ардчилал, тусгаар тогтнол, хүний эрхийг харилцан хүндэтгэж байдгаа та бид харууллаа.

Өнөөдөр манай ард түмэн Америкийн Нэгдсэн Улсын тусгаар тогтнолын тунхагт гарын үсэг зурсны 221 жилийн ойг тэмдэглэж байна.

Тус баримт бичигт тэр үеийн Их Британий арван гурван колони эрх чөлөөгөө олж, тусгаар тогтносон Америкийн Нэгдсэн Улс тунхагласныг нотлон, Америкийн Нэгдсэн Улс тунхагласныг нотлон, Америкийн улс төрийн суурь болсон ардчилал, эрх чөлөөний тухай үзэл санааг илэрхийлсэн юм.

Энэ бол Америкийн баярын өдөр мөн. Гэхдээ, энэ нь зөвхөн америкчуудын төдий асуудал юм гэж үү?

Виржини муж-улсаас төрсөн Америкийн агуу их хүү. Тусгаар тогтнолын Тунхагийг зохиогч, хожим нь манай

гуравдахь Ерөнхийлөгч болсон Томас Жефферсон ч ингэж бодож байгаагүй юм. Үүнийг 1826 оны зургадугаар сарын 26-нд Вашингтон тойргийн иргэдэд түүний бичсэн сүүлчийн захидал илт харуулж байна. Түүндээ тэр нас сүүдэр өндөр болж, эрүүл мэнд муу байгаа учир Тусгаар тогтнолын Тунхагт гарын үсэг зурсны тавин жилийн ойн ёслолын ажиллагаанд оролцож чадахгүйгээ тайлбарлаад, Тусгаар тогтнолын Тунхагийн бүх нийтийн ач холбогдлыг дурдан бичихдээ: “Тунхаг нь ойрын үед дэлхийн зарим хэсэгт, бусад зарим нь нэлээд хожим, эцсийн эцэст бүх нийтэд ач тусгаа өгч, ард түмэн өөрсдийн засгийн газрыг байгуулан, аюулгүй байдал, аз жаргалтай амьдралаа зохиохын дохио болно гэж би бодож байна” гээд, цааш нь “Бүхний хараа хүний эрх рүү хандсан бөгөөд хандаж ч байна...Жил бүр энэ өдрийг тэмдэглэхдээ, бид эдгээр эрхийг ямагт санан дурсаж, тэдгээрт хязгааргүй үнэнч гэдгээ батлуулж байвал зохино” гэжээ.

Хэрвээ Жефферсон өнөөдөр амьд байсан бол ардчилалын түгээмэл чанарт түүний итгэж байсан итгэлийн Монгол Улс хэрхэн нотолж байгааг хараад тэр лавтайяа баярлах байсан буйзаа гэж би бодож байна. “Ард түмний засаглалын буянт үйлс”, “Хүний эрх”-ийг эрхэмлэн үзэх талаар Монгол Улсын тавьж буй чармайлтыг хараад сэтгэл хангалуун байх байсан гэж надад бодогдоно. Одоо үед Монголд ирсэн Америк хүн бүхэн яг л ийм сэтгэгдэлтэй буцдагийг би мэднэ.

Ийнхүү АНУ-ын Тусгаар тогтнолын Тунхагт гарын үсэг зурсны ойн баярыг америкчууд, монголчууд хамтдаа тэмдэглэн өнгөрүүлж байна. Та бидэнд ардчилалын зам нээж өгсөн хүмүүсийн өв уламжлал болон ардчилал, хүний эрхийн үнэт зүйлсийг эрхэмлэн үзэх талаар мэдлэг, дадлага, туршлагаа бид хуваалцаж болох юмаа. Ингэснээр манай хоёр орны хооронд өргөжин хөгжиж буй сайн сайхан харилцааны бат бэх үндсийг бидний нийтлэг үнэт зүйлс бэхжүүлж өгнө гэдэгт бид сэтгэл хангалуун байж болно.

Та бидний тэмдэглэж байгаа Америкийн Тусгаар тогтнолын өдрийн төлөө, ардчилал, эрх чөлөөний үнэт зүйлсийн төлөө хундага өргөцгөөхийг та бүхнээс хүсье!